

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Зарим үйлчилгээнд тариф тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 259 дүгээр тогтоол, “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 30-ны А/39 тушаалаар батлагдсан “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1,12.2,12.3, төвийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6.15 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


Нэг. Төрийн байгууллагаас бусад иргэн, хуулийн этгээд “ХУР-Төрийн мэдээлэл солилцооны систем” , “ДАН-Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем”-ийн веб сервисийн үнийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хавсралтад дурдсанаар тогтоосугай.

Хоёр. Хавсралтаар тогтоосон “ХУР-Төрийн мэдээлэл солилцооны систем” , “ДАН-Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем”-ийн холбогдох төлбөрийг тогтоосон хугацаанд Улсын төсөвт төвлөрүүлэхийг Нягтлан бодогч /Д.Сүглэгмаа/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан “ХУР-Төрийн мэдээлэл солилцооны систем” , “ДАН-Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем”-д холбогдсон болон холбогдохоор хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдүүдтэй гэрээг шинэчлэн байгуулж, төлбөр тооцох аргачлал холбогдох үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг Захиргаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Дагвасүмбэрэл/-д даалгасугай.

ЗАХИРАЛ

М.БАТТУЛГА



Үндэсний Дата Төв УТҮГ-ын захирлын
2021 оны 08 дугаар сарын 17-ний өдрийн
А/Б/С тоот тушаалын хавсралт

“Үндэсний дата төв”- УТҮГ-аас “ХУР” системээр дамжуулан
үзүүлэх үйлчилгээний төлбөр

№	Сард амжилттай дуудсан сервисийн тоо	Үнэ ₮	Тайлбар /Бодох аргачлалыг гэрээний нэмэлт/
1.	0-10,000	80₮	0-ээс дээш 10,001 хүртэлх амжилттай дуудсан сервис нэгж бүрийн тоогоор 80 төгрөгөөр,
2.	10,001-100,000	50₮	10,001 дэх дуудалт болон түүнээс дээших 100,001 хүртэлх амжилттай дуудсан сервис нэгж бүрийн тоогоор 50 төгрөг,
3.	100,001-1,000,000	30₮	100,001 дэх дуудалт болон түүнээс дээших 1,000,001 хүртэлх амжилттай дуудсан сервис нэгж бүрийн тоогоор 30 төгрөг,
4.	1,000,001 буюу түүнээс дээш	10₮	1,000,001 дэх дуудалт болон түүнээс дээших амжилттай дуудсан сервис нэгж бүрийн тоогоор 10 төгрөг,